



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 544

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, засаж сэлбэн ашиглах боломжгүй, 2 нэрийн, нийт 3,442,926,164.90 (гурван тэрбум дөрвөн зуун дөчин хоёр сая есөн зуун хорин зургаан мянга нэг зуун жаран дөрвөн төгрөг ерэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулгад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ... дугаар сарын ... ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Киоск /карт уншигч төхөөрөмж, пин код уншигч Хурууны хээ уншигч, Touchscreen LCD, A4 сканнер	10/18/2014	34	ш	27,693,750.00	941,587,500.00	0
2	Киоск /карт уншигч төхөөрөмж, пин код уншигч Хурууны хээ уншигч, Touchscreen LCD, A4 сканнер	9/9/2014	74	ш	33,801,873.85	2,501,338,664.90	0
			108		61,495,623.85	3,442,926,164.90	
	Нийт дүн					3,442,926,164.90 (гурван тэрбум дөрвөн зуун дөчин хоёр сая есөн зуун хорин зургаан мянга нэг зуун жаран дөрвөн төгрөг ерэн мөнгө)	